

ХЯТАДЫН БАРУУН БҮС НУТГИЙН ХӨГЖЛИЙГ ТҮРГЭТГЭХ СТРАТЕГИЙН ХЭРЭГЖИЛТ

*Хаварцэцэг**

Хятад орон баруун бүс нутгийн хөгжлийг түргэтгэх стратеги хэрэгжүүлж эхэлснээс хойших гурван жил гаруй хугацаанд баруун бүс нутгийн 12 муж, хот, ӨЗО үр өгөөжтэй бодлого, арга хэмжээ авч үйлчилгээний орчноо идэвхтэй сайжруулж, хөгжлөө түргэтгэсэн байна. Одоогоор баруун бүс нутгийн хөгжлийг түргэтгэх стратеги ихээхэн ахицтай байгаа ба экологи, эрчим хүч, зам тээвэр болон хотын дэд бүцийг гол болгосон бүтээн байгуулалтын алхаа түргэсч, УААА нэлээд түргэн хөгжиж, эдийн засгийн гол үзүүлэлтийн өсөлтийн хурдчаар бүх Хятадад тэргүүлж байна.

Эдийн засгийн нийт хэмжээ мэдэгдэм нэмэгдэж, өсөлтийн хурд тасралтгүй түргэсэв. Тооцоолсноор, 2002 онд баруун бүс нутгийн 12 муж, хот, ӨЗО-ы ДНБ 2005.2 тэрбум юаньд хүрч, жилд дунджаар 9.4% өссөн нь бүх Хятадын дундаж өсөлтийн хурдаас 1.7 хувиар илүү байна. Нэг хүнд ногдох ДНБ 1999 онд дунджаар 4312 юань байснаа 2002 онд 5512 юань болж 1200 юаниар нэмэгдсэн байна. 2002 оны эхний хагаст баруун бүсийн муж, хот, ӨЗО хэдийгээр SARS-ын нөлөөг хүртсэн боловч УААА түргэн өсч, баруун бүс нутгийн ДНБ өмнөх оны мөн үеийнхээс 10.7% өсч, Юньнаний ДНБ-ий өсөлт бүх Хятадын 8.2%-ийн өсөлтөөс бага байгааг оролцуулахгүйгээр бусад 11 муж, хот, ӨЗО-ы өсөлтийн хурдац бүх Хятадын дундаж түвшингээс дээгүүр байна. Ялангуяа ӨМӨЗО-ны 2002 оны эхний хагас жилийн ДНБ-ний өсөлт өмнөх оны мөн үеийнхээс 15.7% өссөн нь бүх Хятадын дундаж өсөлтийн хурдаас 7.5% түргэн байж, өсөлтийн хурдаар бүх Хятадын 31 муж, хот, ӨЗО-ы дотор тэргүүлсэн байна.

Аж үйлдвэрийн үйлдвэрлэлийн хурд тасралтгүй түргэсч, эдийн засгийн үр ашиг мэдэгдэм дээшлэв. 3 жил гаруйн турш баруун бүс нутгийн 12 муж, хот, ӨЗО томоохон төсөл технологийн өөрчлөлтийг гол болгож, аж үйлдвэржилтийн явцыг түргэн ахиулж, аж үйлдвэрийн үйлдвэрлэл, эдийн засгийн үр ашгаа хамтаар өсгөсөн байна. Тооцоолсноор 2002 онд баруун бүс нутгийн 12 муж, хот, ӨЗО-ы аж үйлдвэрийн нийт нэмэгдэл өртөг 639 тэрбум юаньд хүрч, 1999 оныхоос 130 гаруй тэрбум юаниар нэмэгдэж, жилд дунджаар 8.2% өссөн бөгөөд орон

*Хаварцэцэг - БНХАУ-ын Өвөр Монголын Зүүн хойт Ази судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

нутгийн байгалийн баялгийн давуу тал, бүс нутгийн давуу тал бүхий аж үйлдвэрүүд төлөвшиж, нүүрс, эрчим хүч, химийн аж үйлдвэр, төмөрлөг боловсруулах, электрон болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулалтыг гол болгосон тулгуур аж үйлдвэр төлөвшсөн нь баруун бүс нутгийн аж үйлдвэрийн үйлдвэрлэлийн өсөлтийн хурдацад ихээхэн нөлөөлсөн байна. 2002 оны эцсээр баруун бүс нутгийн 12 муж, хот, ӨЗО-ы нүүрс гаргалт бүх Хятадын 26.9%, жилийн цахилгаан гаргалт бүх Хятадын 13%, цементын жилийн үйлдвэрлэлт бүх Хятадын 21%-ийг эзлэв. Үүний зэрэгцээ аж үйлдвэрийн эдийн засгийн үр ашиг ч мэдэгдэм дээшилсэн байна. 2002 онд баруун бүс нутгийн 12 муж, хот, ӨЗО-ы цар хүрээт аж үйлдвэрийн ашгийн нийт хэмжээ 51.9 тэрбумд юаньд хүрсэн нь 1999 оныхоос 44.3 тэрбум юаниар цэвэр өсөв. 2002 оны эхний хагаст баруун бүс нутгийн 12 муж, хот, ӨЗО-ы аж үйлдвэрийн эдийн засаг түргэн хурдаар өсч, баруун бүс нутгийн эдийн засгийн өсөлтийн чухал хөдөлгөх хүчин болсон байна. Баруун бүс нутгийн 12 муж, хот, ӨЗО-ы цар хүрээт аж үйлдвэрийн нэмэгдэл өртгийн өсөлтийн хурд бүх Хятадаас түргэн байгаа муж, хот, ӨЗО 4 бий. Үүнээс ӨМӨЗО-ы цар хүрээт аж үйлдвэрийн өсөлтийн хурд 27.8% болж, Хайнань мужийн дараа орж, бүх Хятадад 2-р байр, баруун бүс нутагт 1-р байр эзэлж байна. 2002 оны эхний 5 сард баруун бүс нутгийн аж үйлдвэрийн аж ахуйн нэгжийн ашиг 81 тэрбум гаруй юаньд хүрсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 1 дахин илүү өссөн байна.

Үндсэн хөрөнгийн хөрөнгө оруулалт өндөр хурдтай өсч, томоохон төслийн бүтээн байгуулалт түргэсэв. 3 жил гаруйн турш, баруун бүс нутгийн муж, хот, ӨЗО экологийн бүтээн байгуулалт, дэд бүтэц болон үндсэн аж үйлдвэрийн бүтээн байгуулалтыг гол болгож үндсэн хөрөнгийн хөрөнгө оруулалтыг эрчимжүүлэв. 2000-2002 оны хооронд баруун бүс нутгийн үндсэн хөрөнгийн нийт хөрөнгө оруулалт 2230 тэрбум юаньд хүрсэн нь бүх Хятадын мөн үеийн үндсэн хөрөнгийн хөрөнгө оруулалтын 21.3%-ийг эзлэв. Томоохон төслийн бүтээн байгуулалтын ахиц сайн байна. 3 жилд нийтдээ 36 томоохон төсөл эхлүүлж, нийт 600 гаруй тэрбум юаний хөрөнгө оруулснаас 2002 оны эцсээр 200 гаруй тэрбум юанийг биелүүллэв. 2002 онд Хятадын баруун бүс нутагт 14 томоохон төсөл шинээр хэрэгжүүлж, нийт 130 гаруй тэрбум юаний хөрөнгө оруулжээ. Одоогоор тариа тарихыг болиулж өвс, мод тарих шинэ төсөл ахицтай болов. Хөх нуур-Төвдийн төмөр замын төсөл ажлаа эхлүүлэв. Баруун бүс нутгийн цахилгааныг зүүн тийш хүргэх төслийн урд алын замын бүтээн байгуулалт бүх талаар

эхэлж, баруун бүс нутгийн байгалийн хийг зүүн тийш хүргэх төсөл албан ёсоор эхлэв. Улсын зээлийн бэлэн мөнгөний ихээхэн дэмжлэгээр баруун бүс нутаг Хятадын хөрөнгө оруулалтын халуун цэг болсон байна. Тариалангийн экологийн бүтээн байгуулалтаар жишээлэхэд баруун бүс нутгийн экологи байгаль орчны бүтээн байгуулалт бүх талаар хэрэгжиж, 3 жилийн өмнө маш муудсан экологийн орчин сайжирч эхэлсний зэрэгцээ тариачны орлого ч тасралтгүй нэмэгдэн, ядуурлаас салж, баяжих нь улам түргэссэн байна. 2002 оны эхний хагас гэхэд баруун бүс нутагт тариа тарихыг болиулж, өвс мод тарьсан талбай 190 сая мүү болж, байгалийн ойг хамгаалах төсөл нийт 22.87 сая мүүд хүрч, онгоцоор 25.49 сая мүү мод тарьж, хамгаалсан ой 85.69 сая мүү болж, 4.1 сая тариачин айл, 16 сая гаруй тариачдыг тариа тарихыг болиулж, өвс мод тарих төслийн бодлогыг хэрэгжүүлсний ач тусыг хүртэн, айл бүр дунджаар 870 кг тэтгэмжийн амуу будаа, бэлэн мөнгөний тэтгэлэг 146 юань авах болж, бүс нутгийн хөдөө тосгоны аж үйлдвэрийн бүтцийн зохицуулалтыг ихээхэн ахиулсан байна. Үүнээс гадна Хөх нуур-Төвдийн төмөр замын 246 км хэсгийг засаж, баруун бүс нутгийн цахилгааныг Гуандунд хүргэх хүчин чадал 5 сая киловатыг давсан байна. 2001 он гэхэд баруун бүс нутгийн шилэн кабелийн шугамын урт 400 мянган км-ээс давж телефон 100 хүн тутамд 14.63 ширхэг ногдох болов. 2002 оны эхний хагаст баруун бүс нутгийн 12 муж, хот, ӨЗО-ы хот суурингаас дээших байгууллагын хийсэн үндсэн хөрөнгийн хөрөнгө оруулалт 308.2 тэрбум юаньд хүрсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 45.4% өсөж, бүх Хятадынхаас 14.3% дээгүүр байж, бүх Хятадын хот суурингаас дээших байгууллагын үндсэн хөрөнгийн хөрөнгө оруулалтын хэмжээ 20.4%-ийг эзэлж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 1.7%-иар дээшилжээ.

Шинжлэх ухаан боловсролоор улсаа мандуулах стратеги бүх талаар хэрэгжиж, нийгмийн төрөл бүрийн ажил тасралтгүй амжилт олов. 2002 онд баруун бүс нутгийн 12 муж, хот, ӨЗО-ы их, дээд сургуулийн оюутны тоо 1 сая 933 мянгалд хүрсэн нь 1999 оныхоос 1 сая 63 мянгаар нэмэгдэн, 1.22 дахин өсч, жилд дунджаар 30% өсөв. “Тосгон бүхэнд радио телевизтэй болгох” төсөл мэдэгдэм үр ашигтай болов. Шинжлэх ухаан техник бол нэгдүгээр үйлдвэрлэлийн хүч гэдэг санаа хүмүүсийн сэтгэлд улам гүнзгий хүрч, шинжлэх ухаан технологийн тогтолцооны өөрчлөлт түргэсч, бие даасан оюуны өмчийн эрхтэй шинжлэх ухаан технологийн чанартай аж үйлдвэрүүд төлөвшиж, шинжлэх ухааныг удирдамж болгосон манлайлагч аж ахуйн нэгжүүд өргөн цар хүрээтэй болжээ. Тухайлбал, ӨМӨЗО-ы Шинжлэх ухаан

технологийн танхимаас мэргэжилтнийг зохион байгуулж нотолгоо хийлгэн, хянан зөвшөөрч газар дээр нь очиж шинжилгээ хийлгэсэн Өвөр Монголын Ордос хотын Үүшин хошууны эрдэнэ шиш тарих, Түнляо хотын Кайлү сяний хатаасан халуун ногоо, Ордос хотын Отог хошууны ноолуурын ямаа бойжуулах, Бугат хотын хүнсний ногооны сайн үрийг бойжуулах, Ордос хотын Отогийн өмнөд хошууны зээргэнэ тарих, Түнляо хотын Найман хошууны элсэн цөл газрын экологийг засах, Улаан хад хотын Хишигтэн хошууны элс цөлөрхөг газарт гацуурын сайн үр тарих, Бугат хотын Хөндлөн дүүргийн цэцэг өвс болон Хөх хотын Хорингэр сяний үр тариа зэрэг нь ӨМӨЗО-ы эхний ээлжийн шинжлэх ухаан технологийн өвөрмөц аж үйлдвэрийн бааз болно.

Хот хөдөөгийн оршин суугчдын материаллаг байдал соёлын түвшин мэдэгдэм дээшлэв. 3 жил гаруйн хугацаанд баруун бүс нутаг нь эдийн засгаа хөгжүүлэхийн зэрэгцээ хот хөдөөгийн оршин суугчдын материаллаг соёлын амьдралын түвшинг дээшлүүлэхээр чармайсны дүнд хот, хөдөөгийн оршин суугчдын орлогын түвшин нэлээд их хэмжээгээр нэмэгдэв. 3 жилд баруун бүс нутгийн 12 муж, хот, ӨЗО-ы хот суурингийн оршин суугчдын орлогын өсөлт 6.4-9.2%-ийн хооронд байна.

2002 оны эхний хагаст баруун бүс нутгийн Чүнчин, Гүйжөү, Өвөр Монголын хот суурингийн оршин суугчдын орлогын өсөлтийн хурд бүх Хятадын дундаж түвшингээс түргэн байна. Хөх нуур мужийн өсөлтийн хурд удаан байгааг оролцуулахгүй бол бусад муж, хот, ӨЗО-ы хөдөө тосгоны оршин суугчдын хүн бүрийн дундаж мөнгөн орлогын өсөлт нь бүх Хятадын түвшингээс түргэн байна.

Хятад хэлнээс орчуулсан Л.Бэгзжав